# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 30 өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ НӨХЦЛИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3-р сарын 21-ны өдрийн 3/1066 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зовлолийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн "Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нөхцөл"-д өөрчлөлт орсныг Хавсралт №1-р шинэчлэн баталсугай.
2. Дээрх журам, нөхцөлийг 2026 оны 10-р сарын 1-ны өдрөөс мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Тэмүдэр, "Цамба" Салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, "22 Авто цогцолбор" Салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛОЛИЙН ДАРГА Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 30 өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ЗЭЭЛИЙН ЭРХ НЭЭХ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ, ЗЭЭЛ АШИГЛАХ ХҮСЭЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн "Зээлийн эрх нээх гэрээ"-г хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
2. Компанийн "Зээлийн эрх нээх гэрээ"-ний хавсралт 3 болох "Шугамын зээл ашиглах хүсэлт"-г хавсралт 2-оор шинэчлэн баталсугай.
3. Компанийн "Зээлийн эрх нээх гэрээ" болон "Шугамын зээл ашиглах хүсэлт"-г 2026 оны 10-р сарын 1-ны өдрөөс тус тус мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Тэмүдэр, "Цамба" Салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, "22 Авто цогцолбор" Салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025оны 9 сарын 30 өдөр | Дугаар 14 | Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ДУГААРЫН ЗЭЭЛИЙН БОЛОН БАРЬЦААНЫ ГЭРЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дугаар заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн "Дугаарын болон барьцааны гэрээ"-г Хавсралт №1-р баталсугай.
2. Компанийн "Дугаарын болон барьцааны гэрээ"-г 2026 оны 10-р сарын 1-ны өдрөөс мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Тэмүдэр, "Цамба" Салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, "22 Авто цогцолбор" Салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 30 өдөр | Дугаар 15 | Улаанбаатар хот

## КОМПАНИЙН БАРЬЦАА ХӨРӨНГӨ/АВТОМАШИН/ ХУРААН АВАХ МЭДЭГДЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн "Хугацаа хэтэрсэн зээлийн барьцаа хөрөнгийг хураан авах, оношилгоо үнэлгээд оруулах, худалдан борлуулах тухай мэдэгдэл"-г хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
2. Компанийн "Хугацаа хэтэрсэн зээлийн барьцаа хөрөнгийг хураан авах, оношилгоо үнэлгээд оруулах, худалдан борлуулах тухай мэдэгдэл"-г 2026 оны 10-р сарын 1-ны өдрөөс мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Тэмүдэр, "Цамба" Салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, "22 Авто цогцолбор" Салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 30 өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ЗЭЭЛ ХҮСЭГЧИЙН АНКЕТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

4. Компанийн "Зээл хүсэгчийн анкет /Иргэн/"-г хавсралт 1-р шинэчлэн батлуулсугай.
5. Компанийн "Зээл хүсэгчийн анкет /Хуулийн этгээд/" хавсралт 2-р шинэчлэн батлуулсугай.
6. Компанийн "Зээл хүсэгчийн анкет /Иргэн, Хуулийн этгээд/"-г 2026 оны 10-р сарын 1-ны өдрөөс мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Тэмүдэр, "Цамба" Салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, "22 Авто цогцолбор" Салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЧИНЗОРИГ

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 9 сарын 30 өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТҮР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.7 дох заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Гүйцэтгэх захирал Ч.Тэмүдэр нь 2026 оны 10-р сарын 2-ний өдрөөс 2026 оны 10-р сарын 13-ны өдрийг дуустал томилолтоор явахтай холбогдуулан компанийн Гүйцэтгэх захирлыг түр орлох ажилтнаар компанийн Эрсдэл хариуцсан менежер Батбаатар овогтой Намуунзул /УП00280767/-ийг тус хугацаанд түр томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЧИНЗОРИГ